



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө аж ахуйн их сургуулийн Инженер технологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Хүнсний инженерчлэл

Индекс: D072101

Шинжээчийн баг:

Ахлагч:	Д.Энхцэцэг	/Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Багшийн сургуулийн дэд профессор, доктор/
Гишүүд:	Я.Баярхүү	/Идэр Их сургуулийн Хүнсний технологийн зөвлөх багш, доктор/
	С.Зулцэцэг	/АПУ ХХК-ийн төв лабораторийн менежер, доктор/

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АМДС-Ажил мэргэжлийн дээд сургууль

АЭС- Агро Экологийн сургууль

БСШУЯ- Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам

ЕБС- Ерөнхий боловсролын сургууль

ЕШ- Ерөнхий шалгалт

ИС- Инженерийн сургууль

ИТС- Инженер технологийн сургууль

Кр- Кредит цаг

МАА- Мал Аж Ахуй

МААБС- Мал аж ахуй био технологийн сургууль

МДС- Магистр докторын сургууль

МИДСК- Монголын их дээд сургуулийн концерциум

МЭС- Мал эмнэлгийн сургууль

ОҮНС- Оюутны үнэлгээний нэгдсэн систем

ОХЭДТ- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв

ОЭШ- Оюутны эрдэм шинжилгээ

ӨМӨЗО- Өвөр Монголын Өөртөө засах орон

СБЗА- Сургалтын бодлого зохицуулалтын алба

ХАА- Хөдөө аж ахуй

ХААА- Хөдөө аж ахуйн академи

ХААИС- Хөдөө аж ахуйн их сургууль

ХААШУТС- Хөдөө аж ахуй технологийн их сургууль

ХАБЭА- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй

ХИГМТ- Хүнсний инженерчлэл, гидромеханикийн тэнхим

ХХААХҮЯ- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам

ШУТДБ- Шинжлэх ухаан дэвшлийн бодлого

ШУТС- Шинжлэх ухаан технологийн сан

ЭЕШ- Элсэлтийн ерөнхий шалгалт

ЭШБХ- Эрдэм шинжилгээний бага хурал

CAD- Computer Aided Design

CDIO- Conceive Design Implement Operate

CNC- Computerized Numerical Control

LMS- Learning Management System

PLC- Programmable Logic Controller

PDCA- Plan Do Check Act

STEEP- Social Technological Economic Ecological Political

SWOT- Strengths Weakness Opportunities Treats

ULMS- Universal Learning Management SYSTEM

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Хөдөө аж ахуйн их сургууль, Инженер технологийн сургууль Mongolian University of Life Sciences, School of engineering and technology	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хүнсний инженерчлэл Food engineering	
Индекс	D072101	
Шинжээчид	1. Д.Энхцэцэг (МУБИС-ийн дэд профессор) 2. Я.Баярхүү (Идэр их сургуулийн зөвлөх профессор) 3. С.Зулцэцэг (АПУ компанийн төв лабораторийн менежер, доктор)	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр/цаг	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021-03-09 10:30-11:00	Нээлт
	11:00-12:00	Сургуулийн орчин нөхцөл, лаборатори, анги танхим, номын сантай танилцах.
	12:00-13:00	Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцах
	13:00-14:00	Завсарлага
	14:00-15:00	Оюутнуудтай хийх уулзалт /цахим/
	15:00-16:00	Багш нартай хийх уулзалт
	2021-03-10 10:00-11:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах.
	11:00-12:00	Ажил олгогчидтой хийх уулзалт /цахим/
	12:00-13:00	Төгсөгчидтэй хийх уулзалт /цахим/
	13:00-14:00	Завсарлага
	14:00-15:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, шинжээчийн багийн уулзалт
	15:30-16:00	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэх

Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2014 оны А/174 тоот тушаал, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан болон холбогдох бусад заавар, эрхзүйн баримт бичиг
--	--

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Хүнсний инженерчлэл мэргэжлийн хөтөлбөрөөр суралцснаар хүнсний түүхий эдийг орчин үеийн дэвшилтэт болон уламжлалт технологиор боловсруулж, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын эрүүл мэндийг хүнсээр дамжуулан сахин хамгаалах, нөөцийг зохистой ашиглах талаар зохих мэдлэг чадвар эзэмшсэн, зохион бүтээх хүсэл эрмэлзлэл, бие даасан бүтээлч сэтгэлгээ, харилцааны соёл, гадаад хэлний зохих мэдлэгтэй, тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх бүхий мэргэжилтэн бэлтгэгдэнэ.

Дээрх чиглэлээр бэлтгэгдэж буй мэргэжилтэн шинжлэх ухаан, боловсрол, ХАА-н үйлдвэрлэл болон аж ахуйн нэгжүүдэд хүнсний технологич, инженер техникийн ажилтан, чанар болон бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мэргэжилтэн, удирдах ажилтан, судлаач; төрийн захиргааны байгууллагад хүнсний асуудал эрхэлсэн байцаагч, мэргэжилтэн зэрэг албан тушаалд ажиллахаас гадна хувийн бизнес эрхлэгч менежер зэрэгт албан тушаалд ажиллах

Хөтөлбөрийн нэр: Хүнсний инженерчлэл

Хөтөлбөрийн мэргэших чиглэл: Хүнсний үйлдвэрлэлийн технологич инженер

Хөтөлбөрийн индекс: D072101

ХӨТӨЛБӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ: Хүнсний инженерчлэл мэргэжлийн хөтөлбөрөөр суралцснаар хүнсний түүхий эдийг орчин үеийн дэвшилтэт болон уламжлалт технологиор боловсруулж, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын эрүүл мэндийг хүнсээр дамжуулан сахин хамгаалах, нөөцийг зохистой ашиглах талаар зохих мэдлэг чадвар эзэмшсэн, зохион бүтээх хүсэл эрмэлзлэл, бие даасан бүтээлч сэтгэлгээ, харилцааны соёл, гадаад хэлний зохих мэдлэгтэй, тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх бүхий мэргэжилтэн бэлтгэх

СУРГАЛТ ЯВУУЛЖ ИРСЭН ТҮҮХ, ТУРШЛАГА

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн (хуучин нэрээр) 1960 оны 293-р тогтоолоор ХААДС-ийн харьяанд ХАА-н механикжуулах, цахилгаанжуулах факультет байгуулагдсанаар тус Инженерийн сургуулийн эх суурь тавигдаж, хөдөө аж ахуйн салбарт анх удаа дотооддоо инженерийн мэргэжилтэй боловсон хүчнийг ХАА-н инженер механик чиглэлээр бэлтгэж эхэлсэн байдаг. 2002 онд Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас “Хүнсний инженерчлэл” бакалаврын боловсролын зэргийн тусгай зөвшөөрөл авч “Үйлдвэрлэлийн үндэсний технологи” мэргэжлээр 2003 онд анхны элсэгчдийг авч мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн. Хүнсний үйлдвэрлэлийн технологич инженер мэргэжлээр бакалаврын сургалтыг 17 дахь жилдээ явуулж энэхүү хөтөлбөрөөр мэргэжлийн тодорхойлолт, мэргэжилтний загвар, ажлын байрны тодорхойлолтод нийцсэн бакалаврын зэрэгтэй, техникийн өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгоход шаардагдах нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллаж ирсэн туршлагатай.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- ХНХЯ-ны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа
- “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрийн STEEP шинжилгээ
- Элсэгчдийн элсэлтийн шалгалтын дундаж оноог сүүлийн 5 жилээр задлан шинжилсэн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн баримталж байгаа төлөвлөлтийн баримт бичиг “ХААН КАМПУС” хөтөлбөр нь 2019-2028 хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө
- Ижил мэргэжилтэн бэлтгэдэг Дотоодын 1, Гадаадын 6 их сургуулийн хөтөлбөрүүдийг харьцуулан судалсан.

Анхаарах асуудал:

- Тухайн мэргэжлийн үнэ цэн, эрэлт хэрэгцээг нийгэмд сурталчилж, элсэгчдийн чанар ба тоонд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Зөвлөмжлөх зүйлгүй

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС, ИТС, Тэнхэм, Тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, алсын хараа, үзэл баримтлалыг харилцан уялдаа холбоотой тодорхойлж өгсөн байдал
- “Хүнс үйлдвэрлэлийн технологич инженер” мэргэжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааны стратеги, загвар
- Төгсөгчийн (мэргэжилтний) загварыг салбар ШУ-ы, Хувь хүний, харилцааны, үйлдвэр ба нийгмийн үйл ажиллагаа явуулах чадвар талаас нь тодорхойлсон байдал

- Төгсөгчдийн эзэмших (PLO) мэдлэг, ур чадвар, хандлагын тодорхойлолт
- Оролцогч ба сонирхогч талуудын эрэлт хэрэгцээн дээр суурилан хөтөлбөрийн шинэчлэлийг 2003 оноос хойш 4 удаа сайжруулан шинэчилсэн баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн жил нь Периодын системээр үргэлжилдэг.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөний 1 цикл бүтэн хэрэгжсэний дараа сургалтын нэгдсэн төлөвлөгөөг шинэчилж байх

Зөвлөмж:

- Жил бүр оролцогч болон сонирхогч талуудын уулзалтыг уламжлал болгож техник технологийн хувьд хурдацтай хөгжиж буй энэхүү салбарынхаа эрэлт хэрэгцээг судалж байх

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ы сайдын холбогдох тушаалууд
- ХААИС-ийн захирлын холбогдох тушаалууд
- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас авсан суралцагчид, багш нар, төгсөгчид, ажил олгогчид, салбарын яам мэргэжлийн байгууллагаас авсан сэтгэл ханамжийн судалгаа, дүгнэлтүүд
- Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалтууд
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг ур чадварууд хөтөлбөрийн зорилтуудын хоорондын уялдаа холбоо

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн хөтөлбөрөөр ХАА-н түүхий эдийн анхан шатны боловсруулалтын мэдлэгийг олгодог (Монгол орон МАА-н орон билээ)

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийнхээ CLO-г тодорхойлж хөтөлбөрийн хүрэх үр дүн PLO-г бүрдүүлэхэд хэрхэн холбогдож байгааг нарийн тодорхойлох
- Ерөнхий суурь хичээл нь 30%-аас ихгүй, Мэргэшүүлэх хичээлүүд нь 45%-аас багагүй байлгах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн захирлын 2015.10.24-ний А/326 тушаал
- ХААИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын албаны жилийн ажлын төлөвлөлт
- Хичээл бүрийн стандарт LMS системд байршуулсан
- Суралцагчдын хичээл сонголтын судалгаа
- Сургалт үйлдвэрлэлийн дадлагын талаарх санал асуулгын судалгаа, дүгнэлт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Суралцагчдын жилд танхимд судлах цагийн ачааллыг судлахын зэрэгцээ Бие даах ажлын ачааллыг судлах хэрэгтэй

Зөвлөмж:

- Период бүрийн Суралцагчдын бие даалтын ачааллыг судлах хэрэгтэй.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ы сайдын 2014.04.28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэлд тавигдах нийтлэг шаардлага”
- Албан ёсны эрхтэй программ хангамжууд
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаанууд, түүний мөрөөр хийгдсэн ажлууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- CDIO-г сургалтад нэвтрүүлсэн
- Дадлага хийж байсан байгууллагын эрэлтэд нийцсэн судалгааны ажил хийх, улмаар тухайн газраа ажилд орох боломж бололцоо байдаг.

Анхаарах асуудал:

- Одоогийн цаг үеийн байдлаас үүдсэн онлайн сургалтдаа лаборатори хичээлүүдийг хэрхэн үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Төгсөөд хаана ажиллахаа төлөвлөсөн суралцагчдад тэр ажлын байр уруугаа чиглэсэн гүнзгийрүүлэн судлах боломжтой сонгоны хичээлүүдийг сонгох боломжийг илүү олгоход анхаарах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн 2007, 2012, 2015 онуудад гаргасан Суралцагчдын мэдлэг чадварыг дүгнэх журам
- ХААИС-ийн захирлын холбогдох тушаалууд
- Суралцагчид, төгсөгчдийн голч дүнгийн судалгаа, дүгнэлтүүд
- Оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцогчдыг ХИГМТ, ИТС, ХААИС, Улсад хэрхэн оролцсон байдлаар нь судалсан судалгаа
- Төгсөлтийн ажлаа А хамгаалсан оюутны судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөх ангийн оюутан бүр дипломын ажил бичиж хамгаалдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байртай холбоотой мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах болон эргэх холбоог сайжруулах

Зөвлөмж:

- Хичээл заагч багш ямар ч хөндлөнгийн үнэлгээгүйгээр суралцагчдыг 100% үнэлж байгааг өөрчлөх (ӨХ 80:20 эсвэл 70:30 байдлаар үнэлэх)

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2015-2019 онд 55 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 шинэ лаборатори, 160 сая төгрөгөөр 1 шинэ лабораторийг байгуулж сургалтын дадлагажих байрны хангалтыг нэмэгдүүлсэн байдал

- Оюутнуудын бие даалтын өрөөг шинээр бий болгосон байдал
- Спорт заал шинээр байгуулж оюутнуудын эрүүл мэнд, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх орчинг бүрдүүлсэн. “Хатан Туул театр байгуулж олон төрлийн дугуйлангууд хичээллэх боломжтой болгосон баримт
- Номын сангийн үйл ажиллагааг цахимт шилжүүлж гадаад дотоод мэдээллийн урсгалыг нэмэгдүүлснээр оюутнууд орон зайнаас үл хамааран шинэ мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн байдал
- Хичээлийн хэрэглэгдэхүүн болох компьютер, принтер, скайнер гэх мэт хэрэглэгдэхүүнийг хүртээмжийг жил бүр нэмэгдүүлсэн. Оюутнууд бие даан ажиллах болон багаар ажиллах орчинг бүрдүүлсэн ба тэнхим бүрт оюутнуудад зориулсан нэг танхим шинээр бий болгосон баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчинг сүүлийн 5 жилийн дотор маш сайн сайжруулсан. Үйлдвэр аж ахуйн нэгжүүдтэй тогтмол хамтарч ажилладаг ба үүнийхээ үр дүнд орчин үеийн шаардлагад нийцсэн лаборатори, үйлдвэрлэлийн цехүүдийг бий болгосон байна.
- Мэргэжил бүрээр дадлага хичээлийг явуулах лабораторитай, түүнчлэн оюутнууд өөрсдөө бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтын цехүүдийг бий болгосон. Энэ нь онол, дадлага, үйлдвэрлэлийг хослуулсан сургалтын нөхцөлийг бүрдүүлсэн давуу талтай.
- Олон улсын байгууллагуудтай хамтарч ажилладаг. Хамтарсан төслийн шугамаар туршилт судалгааны ажилд нэн шаардлагатай олон улсын шаардлага хангасан лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдээр хангагдсан. Багш, оюутнуудын судалгааны ажлыг явуулах бололцоо хангагдсан.

Анхаарах асуудал:

- Лабораториудын ашиглалтыг илүү үр ашигтай байлгах
- Судалгаа шинжилгээний лабораторийг итгэмжлүүлэх, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг баталгаажуулах
- Төгсөгч оюутнуудыг судалгааны ажилд түлхүү оролцуулах, дадлага туршлагатай чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд илүү төвлөрөх
- Лабораторийн аюулгүй ажиллагааг анхаарах, заавар зааварчилгааг сайжруулах

Зөвлөмж:

- Лабораториудыг тавигдах шаардлагад нийцүүлэх
- Дадлага хичээлийн зааврыг илүү сайжруулах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөртэй холбоотой бүхий үйл ажиллагаа цахимд шилжсэн. Цахим сургалтын 11 хэлбэр, 15 хичээлийн бүрдлийг цахимд шилжүүлсэн баримт
- Багш нарын цахим хичээлд өгсөн үнэлгээний дундаж дүн 90.2%
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжүүд
- Оюутнуудын ирц, оролцоо нэмэгдсэн баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын программ хангамж хангалттай сайн.
- Оюутнуудын сургалтын хэрэгцээнд сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай компьютерүүдээр бүрэн хангагдсан.
- Хичээлийн танхим тус бүр хичээлийн хэрэглэгдэхүүн цахимд хичээллэх хэрэглэгдэхүүнээр хангагдсан.

Анхаарах асуудал:

- Дадлага хичээлийг мэргэжлийн чиглэлийн томоохон үйлдвэр аж ахуй нэгждүүдэд хийлгэж дадлагажуулдаг. Цаашид зах зээлийн шаардлагад нийцүүлсэн сургалтын хөтөлбөрийг шинэчилэн сайжруулахад илүү хамтарч ажиллах

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрийг сайжруулах санал, судалгааг илүү бодитой үр өгөөжтэй болгоход анхаарах. Чанарт төвлөрөх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- 2 салбар номын сантай. Нийт 200,000 гаруй боть ном, CD, судалгааны ажлын материал байна. Судалгааны ажлууд 100% цахимд шилжсэн баримт
- Номын сангийн цахим мэдээллийн сангийн өсөлтөнд дүн шинжилгээ хийж хянаж сайжруулдаг баримт нотолгоо
- Сургуулийн орчин дахь интернэт сүлжээ ашиглалт өссөн дүн
- Сургалт үйл ажиллагаандаа нийт лицензтэй 6 программыг ашигладаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Номын сангийн үйлчилгээ чөлөөт сонголттой болж lib4U программын шинэчилсэн хувилбар технологи дээр суурилсан программ хангамжийг номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлсэн.
- Судалгаа шинжилгээний бүх материалыг цахимд шилжүүлсэн. Энэ нь гадаад, дотоод болон судалгаа хийж буй бусад бүх байгууллага болон судлаачдад илүү нээлттэй болсон.
- Шинээр номын сан баригдаж байгаа ба энэ нь номын сангийн үйл ажиллагаа, хүртээмж илүү сайжрах боломж бүрдсэн байв.
- Олон улсын нэр хүнд бүхий гадаадын цахим мэдээллийн сангуудыг ХААИС-ийн сүлжээнээс ашиглах боломжтой болсон ба хэрэглэгчдийн тоо өндөр өсөлттэй байв.

Зөвлөмж:

- Шинэ олон улсын ном сурах бичгийн захиалга хүртээмжийг нэмэгдүүлэх
- Мэргэшүүлэх хичээлийн номын хүртээмжийг илүү нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Хүнсний инженерчлэл мэргэжлийн хөтөлбөр
- Хүнсний инженерчлэл мэргэжлийн хөтөлбөрийн дагуух дүрэм, журам, зааврууд
- Богино, дунд, урт хугацааны төлөвлөлт, хэрэгжилтийн тайлан
- Ажил олгогчоос ирсэн санал, гомдлыг зохицуулах журам, нэгдсэн тайлан
- Сургалтын удирдлага, мэдээллийн ил тод байдал, бүх төрлийн цахим хэлбэрийн мэдээлэл баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн Хүнсний инженерчлэл мэргэжлийн хөтөлбөрийн хороо 2015 онд байгуулагдсан ба ажил олгогч, төгсөгч оюутнуудыг хороонд оролцуулсан нь илүү бодит хөтөлбөр боловсруулах, үр дүнд тулгуурласан шийдвэр гаргах давуу талтай.
- 2014 онд дээрх хөтөлбөрийг нийт 6 дүрэм, журам, заавар боловсруулж мөрдөж ажилладаг.
- Богино, дунд, урт хугацааны төлөвлөлтийг хийж ажилладаг ба жилдээ нэг удаа дүгнэж хэлэлцдэг.
- Ажил олгогчоос ирсэн санал гомдлыг тэнхим, шаардлагатай тохиолдолд сургуулийн удирдлагад танилцуулж хамтын хурлаар, багш оюутнуудын саналыг хөтөлбөрийн хороогоор дамжуулж шийдвэрлүүлдэг. Гэхдээ одоогоор хөтөлбөрийн хороонд санал гомдол ирээгүй байна.
- Сургалтын удирдлага, мэдээллийн ил тод байдлыг бүх төрлийн цахим хэлбэрээр нээлттэй явуулдаг. Шинээр үйл ажиллагаандаа Uniface 5 системийг нэвтрүүлсэн.

Анхаарах асуудал:

- Богино, дунд, урт хугацааны төлөвлөлтийг богино хугацаанд дүгнэж хэлэлцдэг байх
- Сургалтын хөтөлбөрт олон улсын ISO стандартуудыг оруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөртэй холбоотой бүхий л үйл ажиллагааны сайжруулалтыг үр дүнд төвлөрсөн хэлбэрээр явуулж, тогтмол сайжруулалтыг хийж, хэвших

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Гадаад, дотоод хамтын ажилагаа, тэтгэлэгт хөтөлбөрүүд түүний хэрэгжилт, үр дүн, тайлан
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа, баримт мэдээлэл, давтан сургалтанд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийт гадаадын 4 хүртэлх сургуулиудтай харьцуулсан хөтөлбөрийн судалгаа хийж, давхцал болон бусад сайжруулалтыг хөтөлбөртөө тусгасан.
- БНХАУ-ын Хэнэн мужийн ХААИС-тай Сургалт судалгааний төв байгуулах чиглэлээр, БНСУ-ын КОИСО байгууллагатай газар тариалан, хүнс, эрчим хүчний технологийн гадаад худалдааг хөгжүүлэх чиглэлээр, ХБНГУ-тай оюутан солилцоо болон мэргэжлийн гүнзгийрүүлсэн шаталсан сургалтын чиглэлээр тус тус хамтран ажилладаг. 2019 онд нийт 4 чиглэлээр гадаад дотоодын хамтарсан төсөл хэрэгжүүлсэн.
- Герман улсад нийт 59 оюутан дадлагажиж, 36 оюутан мастерийн, ӨМӨЗО-ны мэргэжлийн сургуульд 2 багш докторантурийн хөтөлбөрт хамрагдсан байна.
- Хоёр улсын хос дипломтой төгсөлтийг хэрэгжүүлсэн ба нийт 4 төгсөгч бэлтгэсэн. Одоо 12 оюутан суралцаж байна.
- Багш нар мэргэжлийн чиглэлээр үйлдвэр аж ахуй нэгж, ферм эрхлэгч нарт зөвлөмж туслалцаа үзүүлж ажилладаг.
- 2015-2020 онд нийт төгсөгчдийн 70.99% ажлын байраар хангагдаж, 62.36% нь мэргэжлээрээ ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны үр дүнтэй байдалд анхаарах, тогтмол үйл ажиллагааг сайжруулах

Зөвлөмж:

- Төгсөгчдийн мэргэжил мэдлэгээс оюутан дүү нартаа хуваалцах үүднээс дадлага чиглэлийн хичээлийг багш нартай хамтран зохион байгуулах, үр өгөөжийг хэлэлцэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хэрэгжилтын жилин төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг оюутанд ноогдох зардал
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн шинэчилэлт өөрчлөлтөд зориулсан төсөв, зардлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2020 онд суралцсан оюутны тоо сүүлийн 5 жилээс 22%-аар буурсан ч сургалтын төлбөр 29%-аар өссөн дүнтэй байгаа нь орлогын жилийн дундаж хэвийн байна тодорхойлсон байна.
- Нэг оюутанд ноогдох зардал 2016 оноос 29% -аар өссөн байна.
- Хөтөлбөрт орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж ажилласанаар лабораториудад хөрөнгө оруулалт хийж чадсан. Мөн шинээр 2021 онд ахин шинэ лабораторийг байгуулах гэрээ хийгдсэн байна. Жил бүр хамтран ажиллах байгууллагуудын тоог нэмэгдүүлсээр орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж ажилласан.
- 2015 оноос аж ахуй нэгж болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж сургуульдаа 946 сая төгрөгийн санхүүжилт хийж чадсан.

Зөвлөмж:

- Дадлага болон лабораторийн хичээлийн үйл ажиллагааны зайлшгүй шаардлагатай урсгал зардлыг тусгах /бодис урвалж, туслах материал, аюулгүй ажиллагаа/
- Багш нарын практик ур чадварыг дээшлүүлэхэд тодорхой санхүүжилтийг төсөвлөх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр тогтвортой байдлаа хангах хөтөлбөр
- Тандалт судалгаа, дүгнэлт холбогдох материал
- Хийсэн ажлын тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн ач холбогдлыг таниулах зорилготой ХААИС-ийн элч оюутанг хөдөө орон нутагт илгээх ажлыг зохион байгуулдаг болсон нь илүү үр дүн өгсөн.
- Сургалтын хөтөлбөрт оюутнууд төлөвлөгөөгөө хурдан хугацаанд ойлгох, хувиараа өөрөө төлөвлөх, мэдээлэл эрж хайх боловсруулах, хариуцлагатай ажил хэрэгч байх, гадаад хэлний мэдлэг, хамтран ажиллах чадвар зэргийг суурь чадварт байхаар тусгаж оруулсан.

Анхаарах асуудал:

- Хүнсний инженерчлэл мэргэжилтний эрэлт зах зээлд их байгаа боловч нийлүүлэлт бага байна. Энэ нь үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагаас ямар мэргэжилтэн хэрэгцээтэй байгаа талаас судалгаа дутуу, мөн түүнчлэн хамтын ажиллагаа хол байгаа нь харагдаж байна. Иймд сургууль аж ахуй нэгжийн хамтарсан ажиллагааг бодлогын түвшинд боловсруулж, яамны түвшинд хэлэлцүүлгэнд оруулж шийдүүлэх тал дээр бусад ижил мэргэжлийн сургуулиудтай хамтарч ажиллах. Хувийн хэвшлүүдэд гэрээтэй мэргэжилтэн бэлтгэх талаар гэрээ хийж ажиллах, үр өгөөжийн дүгнэдэг байх.

Зөвлөмж:

- Дадлага хичээлийг хуваарийг үйлдвэр аж ахуйн нэгж дээр хийлгэхдээ жилээр хийх, хавсралтаар дадлага хийх ангиуд, хугацааг тодорхой оруулах. Энэ нь үйлдвэр аж ахуй нэгжийн зохион байгуулалтанд тустай байдгийг анхаарах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг веб сайт, сургалтын хөтөлбөр
- Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа, тайлан, баримт
-

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүх төрлийн арга зам, хэрэгслүүлийг ашигладаг.
- Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааны тоо, давтамж болон тайлангийн мэдээлэл хангалттай.

Зөвлөмж:

- Ажлын байран дээр ажил ахалж ажиллаж буй төгсөгчдийн саналыг судалгаа болон хөтөлбөрт тусгаж байх
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд сүүлийн үеийн мэдээллийг түгээхэд анхаарч ажиллах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ–аас батлагдсан мэргэжлийн сургуулийн элсэлтийн үлгэрчилсэн журам, БСШУС-ын А/79 тоот тушаалаар баталсан журамд нийцүүлэн ХААИС-элсэлтийн журмыг жил бүр шинэчлэн боловсруулж, мөрддөг. (А/37 тоот тушаал)
- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тогтоосон байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Оюутны гарын авлага
- “ХААИС-ийн элч оюутан”, “Миний мэргэжил миний ирээдүй” зэрэг хөтөлбөрүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрөөр “технологич инженер” бэлтгэдэг ба тухайн мэргэжлийн ангид элсэгчдийг ЭЕШ–ын физик, математик хичээлийн аль нэг өндөр оноог харгалзан элсүүлдэг. Элсэгчдийн ЕШ–ын дундаж оноо сүүлийн 5 жилд 490-554 байгаа нь босго онооноос 50-74 оноогоор илүү байна.
- Шинээр элссэн оюутнуудад чиглүүлэх сургалтыг тусгай хуваарийн дагуу явуулдаг ба энэ хүрээнд “Мэргэжлийн удиртгал” хичээлийг 2 кр-ээр орж оюутнуудад мэргэжлийн чиг баримжаа олгох, өөрийн мэргэжлийн онцлог давуу талыг мэдрэх, мэргэжилдээ дур сонирхолтой болоход нь дэмжлэг үзүүлдэг. Мөн мэргэжлийн сурталчилгаанд Монголын сурагчдын холбоотой хамтарсан “Миний мэргэжил миний ирээдүй”, Монголын бүх сумдад сурталчилгаа хийдэг “ХААИС-ийн элч оюутан” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Шинээр элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалт болон мэргэжлийн сурталчилгааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, сайжруулж ажилладаг байх

Зөвлөмж:

- ЭЕШ–ын нэг хичээлээр элсүүлэх биш 2 дахь шалгалтын оноог 50% -иар ч юмуу тооцдог болох

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Хаан кампус” стратеги төлөвлөгөөн дэх зөвлөн хөгжүүлэх төлөвлөгөө, түүнд хийсэн PDCA шинжилгээ
- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас гаргадаг нэгдсэн төлөвлөгөө, график
- Эдийн засгийн хөгжлийн албанаас нэгтгэн гаргадаг сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Зөвлөх багш, сургалтын алба, байрын багш, эмчийн зөвлөн туслах үйлчилгээний чанарын үнэлгээ
- Суралцагчдын дунд зохион байгуулсан соёл хүмүүжлийн болон мэргэжлийн уралдаан тэмцээний тайлан
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд зарцуулсан зардал, гаргасан амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас оюутныг зөвлөн хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг сургалтын хуанлитай уялдуулан гаргаж, бүрэлдэхүүн сургуулиуд түүнийг мөрдлөг болгон ажилладаг. Оюутанд чиглэсэн сургалтын 6, нийгмийн халамжийн 8 үйлчилгээг хэрэгжүүлдэг ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмж тусгаад байна.

- Зөвлөн хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэнд сургалтын алба хяналт тавьж, үнэлгээ өгөхөөс гадна чанарын баталгаажуулалтын нэгжээс хөндлөнгийн үнэлгээ хийдэг. Зөвлөн туслах үйлчилгээний талаархи сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч үр дүнг нэгтгэн, цаашид анхаарах асуудлыг зөвлөмж болгон гаргадаг. Зөвлөмжийн үр дүнд оюутны дотуур байранд бие даалтын өрөө, орчин үеийн шаардлагад нийцсэн гал тогоо, интернетийн үйлчилгээг бүрэн шийдвэрлэсэн байна. Мөн зөвлөх багш оюутныг элсэн суралцахаас төгсөх хүртэлх хугацаанд хичээлээ зөв сонгох, сурах үйл явцаа оновчтой төлөвлөх зэргээр амжилттай сайн суралцахад нь дэмжин тусалж ажилладаг. Санал асуулгад оролцсон оюутны 90,2% нь сэтгэл ханамж сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.
- “Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлын журам”-д заасны дагуу оюутан эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, судалгааны ажлыг шалгаруулах, санхүүжүүлэх, урамшуулах зэргээр дэмжин ажилласны дүнд судалгааны ажил гүйцэтгэх болон эрдэм шинжилгээний хуралд оролцох оюутны тоо нэмэгдэж, сүүлийн 3 жилд 10 оюутан сургуулийн эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн байна.
- ХААИС-ийн захирлын А/183 тоот тушаалын дагуу “Хүнсний үйлдвэрийн технологич инженер” мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгасан Гамшгаас хамгаалах менежмент, Биеийн тамир, эрүүл ахуй, Хүний хөгжил, харилцааны ёс зүй зэрэг хичээлүүдийг судласнаар бие хүний төлөвших, эрүүл аж төрөх, харилцааны ёс зүйтэй байх гэх мэт ур чадваруудыг эзэмших боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Оюутан судалгааны шинжилгээний ажил гүйцэтгэх орчин, нөхцлийг сайжруулах

Зөвлөмж:

- Оюутнуудын судалгаа шинжилгээний ажлын оролцоог нэмэгдүүлэх
- Оюутанд чиглэсэн үйлчилгээний чанарын үнэлгээний судалгааг тогтмолжуулж харьцуулан дүгнэж, үр өгөөжийг тооцдог байх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Урлагч”, “Persistent” клубуудийн хөтөлбөр, үйл ажиллагааны тайлан
- Оюутны байгууллагын үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, төсвийн зарцуулалт, зохион байгуулсан ажлын тайлан
- Оюутны сайн дурын үйл ажиллагааны тайлан, дэмжсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ИТС-ийн оюутны зөвлөлийн даргаар А.Алтанбагана ажиллаж оюутнуудыг нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд оролцуулах, урлаг, спортын хувьд хөгжүүлэхийн тулд ажлаа төлөвлөн төсөв батлуулж, сургуулийн захиргаанаас дэмжлэг авч хамтран ажилладаг. Оюутнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, оюутныг хөгжүүлэх зорилгоор техник, урлаг, спорт, цэнгээнт бүжгийн 30 орчим клуб, дугуйлан хичээллэдэг. “PERSISTENT” клуб нь зөв хандлагатай инженер болох уриа дэвшүүлэн хоёр зөвлөх багш, 8 гишүүдтэй үйл ажиллагаа явуулдаг. Оюутны бүтээлч сэтгэлгээ, зөв хандлагыг хөгжүүлэх,

төлөвшүүлэх, мэргэжлийн хэлний түвшинг нэмэгдүүлэх зорилгоор сургалт явуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэргээр ажиллаж үр дүнг олонд түгээхийн тулд тайлан, үзэсгэлэн гаргадаг.

- Оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг “Цэвэр орчин бидний сургууль”, “Ургац хураалт”, “Хог цэвэрлэгээ challenge” зэрэг сайн дурын аяны хүрээн дэх ажлуудыг жил бүр зохион байгуулж, оюутныг бие бялдар, оюун санааны хувьд төлөвшүүлдэг төдийгүй оны эцэст шалгаруулдаг шилдэг оюутны нэг шалгуур болгодог. Оюутны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх зорилгоор “Мэргэжил сурталчлах өдөрлөг”-ийг зохион явуулахаас гадна их дээд сургуулиудын дунд жил бүр зохиогддог “Үйлдвэрлэлийн процесс аппарат” улсын олимпиадад оролцогч болон зохион байгуулагчаар баг бүрдүүлж амжилттай оролцдог уламжлалтай.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд ХААИС-ийн ректорын 289 тоот тушаалаар ХААИС-ийн оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдан даргаар нь багш Лхагвасүрэн ажиллаж байна. (2009 он). Энэ төв нь өөрийн цахим хуудсаар дамжуулан оюутнуудад зөвлөгөө, мэдээлэл хүргэдэг. Бүртгүүлсэн оюутны 35% -д зөвлөгөө өгч, 5,4%-ийг цалинтэй дадлага хийх боломжоор хангаж, 4%-ийг цагийн ажилд зуучилсан байна.
- ИТС-ийн оюутнууд эрдэм шинжилгээ-судалгааны ажил хийж, урлаг, спортын амжилт гаргасан тохиолдолд шилдэг оюутнаар өргөмжилж, мөнгөн урамшуулал олгодог. Сурлагын хувьд 3,7 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан бол “Ректорын нэрэмжит батламж” олгож, батламжийг 3 удаа авсан оюутныг шилдэг оюутнаар өргөмжлөн “Ректорын нэрэмжит тэтгэлэг” буюу сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлт үзүүлдэг. Тайлангийн хугацаанд батламжийг 150 оюутан авснаас 7 оюутан сургалтын төлбөрийн 20%-ийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй ч үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, оюутан бүрт хүрч ажиллаж чадахгүй байгаад дүгнэлт хийх
- Оюутны сайн дурын ажлыг дэмжих, үнэлгээг тодорхой болгох

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оюутнуудын цагийн ажил эрхлэх хүсэл сонирхол, хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаатай ажиллах
- Тус хөтөлбөрийн оюутнуудын гадны тэтгэлэгт хамрагдах байдалд үнэлэлт өгч нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллах
- Клубүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, тайлан, үзэсгэлэн гаргаж олонд таниулах, хүртээмжийг нэмэгдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны шилжилт, хөдөлгөөний журам
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны шилжилт хөдөлгөөний асуудлыг улирал бүрийн эхэнд зөвлөх багшийн хүсэлт, оюутны өргөдлийг үндэслэн “Оюутны шилжилт хөдөлгөөний журам”-ын дагуу шийдвэрлэдэг. Эхний 4 улирал буюу 60-аас илүүгүй багц цаг цуглуулах хугацаанд бусад сургуулиас шилжин суралцаж болдог.
- Тайлангийн хугацаанд шилжин ирж суралцсан оюутны тоо шилжсэн оюутны тооноос 3 дахин их байна. Сурлагаар хасагдсан оюутны тоо сүүлийн 3 жилд буурсан нь зөвлөх багшийн зөвлөн туслах үйлчилгээний үр дүн, сургалтын орчны сайжруулалттай холбоотой. Харин оюутнууд жилийн чөлөө авах тохиолдолд санхүүгийн боломжгүй байдал, эмэгтэй оюутан төрөх зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.

Зөвлөмж:

- Сургуулиа орхисон оюутны шалтгааныг нарийвчлан судалж, цаашид энэ чиглэлээр авах арга хэмжээг төлөвлөдөг байх
- Шилжин ирж суралцаж байгаа оюутны кредит цагийг дүйцүүлэн тооцох журмыг шинэчлэн боловсруулж, мөрдөх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ХИ хөтөлбөрөөр төгсөгчдийн дипломын хуулбар
- Оюутны төгсөлтийн ажлын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрийн бакалаврын зэргийн диплом нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн кредит цаг, үнэлгээ бүхий МУ-ын Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн дугаар, ХААИС–ийн бүртгэлийн дугаартай байх ба ХААИС-ийн удирдах зөвөлийн дарга, захирал, төгсөлтийн комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байна. Сүүлийн 2 жилд “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрөөр төгсөгч оюутан бүр судалгааны ажил болон судалгааны хэсэгтэй төсөл бичиж хамгаалан төгсөж байна.

Зөвлөмж:

- Оюутны төгсөлтийн ажлын сэдвийг оновчтой тогтоох, хөтөлбөрийн онцлог, давуу талыг харуулсан судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх (*хөтөлбөрийн ялгарах чанар болох хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр гэх мэт*)

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- “ХААИС-ийн багшийн хөгжил” хөтөлбөр
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн цагийн ачаалал
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сонгон шалгаруулалтыг 3, 6-р улиралд, дараагийн улирлын хичээл эхлэхээс өмнө зохион байгуулдаг. Мэргэжлийн тэнхим сонгон шалгаруулах багшийн тоог тогтоож, СБЗА-наас зохион байгуулсан сургалтад хамрагдаж 80-аас дээш хувийн үнэлгээ авсан тохиолдолд дараа мэргэжлийн шалгалт авч, багшаар ажиллах асуудлыг захиргааны зөвлөл эцэслэн шийдвэрлэдэг. Мэргэжлийн чиглэлийн докторын зэрэгтэй бол шалгалтаас чөлөөлж, нээлттэй сонгон шалгаруулалтаар ажилд авдаг.
- “ХААИС-ийн багшийн хөгжил” хөтөлбөрийг үндэслэн багшийн хөгжил, чадамжийн түвшинг сургалт заах арга зүй; эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйлчилгээ; багшийн ур чадвар, ахиц дэвшил; нийгмийн үйл ажиллагаа гэсэн 4 чиглэлээр үнэлэн албан тушаалын зэрэглэлийг тогтоодог. Багш нар албан тушаалын 5 зэрэглэлд ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 2 багш ахлах багшаас дэд профессор, 8 дадлагажигчаас 1 нь ахлах багш, 7 нь багш зэрэглэлд дэвшин ажилласан байна.
- 34 багштай, 38% нь докторын зэрэгтэй. Үүнээс мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээл заадаг багш нарын 63% нь доктор. Багш суралцагчийн тооны харьцаа 5-7 байгаа нь улсын дунджаас 50%-иар бага байна. Багшийн жилийн цагийн ачаалал 25 багц цаг бөгөөд сургалтын болон эрдэм шинжилгээний гэсэн 2 хэсгээс тогтоно. А, Б цагийн харьцаа багшийн зэрэглэлээс хамаарна. Багш нэг улиралд 2, хичээлийн жилд 4 төрлийн хичээл заадаг ба багш бүр илүү цагийн мөнгө авдаг. Багшийн ажлыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар нь үнэлж, урамшуулдаг.

Анхаарах асуудал:

- Эрдмийн зэрэг, цолтой багшийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Багш эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, өөрийгөө хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох
- Б цагийн үнэлгээнд зөвхөн эрдэм шинжилгээний ажил төдийгүй бусад ажлууд, тухайлбал, оюутантай ажиллах, нийгэмд чиглэсэн ажлууд багтаж байгаа нь хир оновчтойг судлах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Багшийн заах арга зүйн талаар хийсэн үнэлгээ
- Багшийн хөгжлийн төлөвлөгөө, багшийн ажлын дэвтэр
- Мэргэжил дээшлүүлэлтийн судалгаа, тайлан
- “Хаан кампус” стратеги төлөвлөгөөн дэх багшийн үйл ажиллагааны PDCA шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн тогтвортой хөгжлийг хангах, бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, хувь хүнийг чадавхжуулах зорилго бүхий багшийн хөгжлийн төвтэй. Хөгжлийн төв нь “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд хичээлийн жилийн эхэнд санал авч сургалтыг төлөвлөн зохион байгуулдаг. Багш нарт muls.edu.mn хаягаар сургалтын талаархи мэдээллийг хүргэдэг. Багш бүр хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллаж, тайлангийн хугацаанд 90 гаруй хувь нь сургахуйн ур чадварыг сайжруулах болон гадаад хэлний сургалтад хамрагдсан байна.
- Багшийн хөгжил, мэдлэг, ур чадварыг “Хаан кампус” хөтөлбөрт зааснаар заах арга барил, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгийн түвшингээр үнэлдэг.
- Сүүлийн 5 жилд “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрт мэргэшүүлэх болон мэргэжлийн суурь хичээл ордог багш нар давхардсан тоогоор дотоодод 114, гадаадад 25 багш мэргэжил дээшлүүлсэн байна. Гадаадад мэргэжил дээшлүүлсэн багш нар БНХАУ болон ХБНГУ-д хүнсний аюулгүй байдал, дайвар бүтээгдэхүүний боловсруулалт, сав баглаа боодлын хэрэглээ ашиглалт, шинээр гарч буй хөргөх бодисын хэрэглээний талаар туршлага судалж, түүнийгээ судалгаа, сургалтад хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багшийн мэргэжлийг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- Үйлдвэртэй хамтын хөтөлбөр хэрэгжүүлж, багш нарыг дадлагажуулах, шинэ техник технологит сургах

Зөвлөмж:

- Гадаад болон дотоодод сургалт семинарт хамрагдсан багш нарын ажлын үр дүн, ахиц дэвшлийг үнэлдэг байхаас гадна үзүүлдэг дэмжлэг, урамшууллыг тодорхой болгох
- “Багшийн хөгжлийн төв”-ийн зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны үр дүнг тооцон, өгөөжийг үнэлдэг байх

Шаардлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарыг шат дараатай мэргэшүүлэн чадавхжуулах талаар судалгаатай ажиллаж, эрдмийн зэрэг, цолыг ахиулахад чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн үр дүн

- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрт хичээл заадаг багш нарын 95% нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, сүүлийн 5 жилд нийт 57 оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийж, инновацийн технологийг нутагшуулах ажилд оролцон ажиллаж байна. Энэ хугацаанд шинжлэх ухаан технологийн болон инновацийн 19 төсөл, захиалгат болон гэрээт 47 ажил, олон улсын 40 төслийг амжилттай хэрэгжүүлж, одоо 2 төсөл дээр ажиллаж байна. 2015 онд KOICA, Хангёны их сургуультай хамтарсан “Байгальд ээлтэй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд мах боловсруулах цехийг байгуулсан нь багш, оюутан технологийн туршилт хийх, бүтээгдэхүүний жор, технологи боловсруулах зэргээр мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэхэд үр өгөөжөө өгч байна.
- Жил бүр багш оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, судалгааны ажлын үр дүнг шүүн хэлэлцдэг ба жилд 33-43 өгүүллийг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн бичиг, ХААШУТС-д нийтэлж, олны хүртээл болгосон байна. Импакт фактортай сэтгүүлд 18 өгүүлэл, нийтдээ 11 удаа эшлэгдсэн байна.
- Багш бүр өөрийн заадаг хичээлийн лабораторийн ажлын аргачлалыг ном болгон хэвлэж, сургалтад ашигладаг. Цахим хичээлийн хүрээнд Google Classroom, Google forms, Google Sheets зэрэг программуудыг өргөн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны лабораторийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Багш нар гадаадын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх болон эшлэгдсэн тохиолдолд урамшуулдаг тогтолцоотой болох

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш болон тэнхмийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /аттестатчлал, оюутны үнэлгээ/
- Багшийн сургалтын үйл ажиллагааны баримт, материал
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн жилийн төгсгөлд багш бүр өөрийн үнэлгээний тайланг бичиж, тэнхмээр хэлэлцүүлэн үнэлүүлдэг. Үнэлгээний дундаж 85-95%-ийн биелэлттэй байдаг. Багшийн хөндлөнгийн үнэлгээг “ХААИС-ийн профессор багшийн аттестатчлах журам”, “ХААИС-

ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам”-ын дагуу хийдэг. Багшийн хөгжил, чадамжийн үнэлгээ нь албан тушаалын зэрэглэлээс хамааран үзүүлэлт бүр дээр өөр өөр оноотой байдаг. 2017-2018 оны хичээлийн жилд профессор багшийн чадамжийн түвшинг үндсэн 4, 30 дэд чадварын түвшингээр үнэлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг багш нэг бүрт тусгайлан хүргэсэн. Үүний үр дүнд багш нар өөрийн чадамжийн түвшинд дүгнэлт хийж, сургалтад хамрагдах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх идэвхтэй үйл ажиллагааг хийж эхэлсэн. Энэ үнэлгээг 2 жил тутам явуулдаг ба 2020-2021 оны хуваарийг батлан, сургалтуудыг шат дараатай зохион байгуулж байна. 2019-2020 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 60 багш сургалтад хамрагдаж, сургахуйн чадвараа дээшлүүлж, чадамжийн түвшинг үнэлүүлсэн 7 багш зэрэглэлээ ахиулсан байна. Цахим хичээл орж эхэлсэнтэй холбоотойгоор багш нарын идэвх, ур чадварыг үнэлэх зорилгоор “Шилдэг цахим хичээл” шалгаруулж, мөнгөн шагналаар урамшуулан ажиллаж байна.

- Багшийн ажлын хөндлөнгийн үнэлгээг оюутнуудаас авах онлайн системийг ашиглаж байна. Оюутны үнэлгээ 29 асуулттай бөгөөд сургалтын арга технологи, оюутныг бодитой үнэлдэг байдал, багшийн харилцаа, ёс зүйн талаархи асуудлуудыг багтаасан байдаг. Улирлын төгсгөлд оюутан хичээл заасан багшийг үнэлэх ба судалгааны дүнгээс харахад хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт өгсөн үнэлгээний сэтгэл ханамж 80-аас дээш хувьтай байна.

Анхаарах асуудал:

- Багшийн үнэлгээний системийг цахимжуулах, дүгнэхэд хялбар, боловсронгуй болгох

Зөвлөмж:

- Профессор багш нарын ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарсан урамшууллын тогтолцоог эрэлхийлж, хэрэгжүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Чанарын удирдлага зохицуулалтын албаны бүтэц
- Чанарын баталгаажуулалтын нэгжийн түүхчилсэн үе шат
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалт, дотоод чанарын баталгаажилтын схем
- ХААИС-ийн хяналт шинжилгээ, үнэлгээний журам
- ХААИС-ийн Дотоод аудитын журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хяналт шинжилгээ, үнэлгээний журмын заалтуудыг нарийн тодорхой болгох
- Сургуулийн үйл ажиллагаанд оролцогч талуудын ажлын чанарт анхаарах

Зөвлөмж:

- Нэгжүүд өөр хоорондоо харилцан уялдаатай ажиллахад анхаарах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерийн өсөлт, ажлын байраар хангагдах хүртэлх хугацааны судалгаанууд
- Төгсөгчдийн ажиллаж буй газруудын судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- 2017.09.21 өдрийн А/377-р ХААИС-ийн захирлын тушаал, 2018.03.26 өдрийн А/36-р БСШУЯ-ы сайдын тушаал, 2019.02.27 өдрийн А/14-р ИТС-ийн захирлын тушаалуудаар хөтөлбөрийн хороо болон өөрчлөлтүүд баталгаажигдсан байна.
- Олон улстай хамтран ажиллах талаараа 2000 оноос “Хос хөтөлбөрийн сургалт”-ыг хэрэгжүүлж эхэлсэн баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2000 оноос “Хос хөтөлбөрийн сургалт”-ыг ОХУ, БНХАУ, БНСУ, Канад улстай хамтран хэрэгжүүлдэг.
- Сүүлийн 5 жилд дараагийн шатны хөтөлбөрт 11 төгсөгч ОХУ, БНХАУ, БНСУ-д суралцаж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерийн өсөлт, ажлын байраар хангагдах хүртэлх хугацааны судалгаануудын дүгнэлт болон түүний мөрөөр хийсэн ажлуудыг тодорхой болгох

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн холбоодтой хамтран “Хүнс үйлдвэрлэлийн процесс аппарат” хичээлийн олимпиадад сүүлийн 6 жил энэ хөтөлбөрөөр суралцагчид амжилттай оролцож байгаа баримт
- ШУТИС болон МУИС-тай хамтран ажиллаж лабораторийн ажлыг сайжруулах, туршлага солилцох чиглэлээр ажилладаг уламжлал

- “Хүнсчдийн холбоо”-той хамтран Багш, оюутны ЭШХ, сургалт, ЭШ-ий бүтээл, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нийт төгсөгчдийн 40 орчим хувь нь 5 жилийн дотор карьер өсөлттэй байгаа нь онцлог зүйл юм.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийг мэргэжлийн чиглэлийнх дагуу урт богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулдаг уламжлал бий болгох
- Төгсөгчдийн хэлний чадвар, бичиг баримт боловсруулах чадварт анхаарах
- Гадаадтай харилцаж буй харилцаагаа улам бэхжүүлэн өргөжүүлэх

Зөвлөмж:

- Дотоод хяналт үнэлгээний ажлаа сэтгэл ханамжийн судалгаагаар хязгаарлахгүй, системтэй олон хэлбэрийн үйл ажиллагаа явуулж түүнийгээ боловсронгуй болгох

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3	0	0	
2	Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	
3	Сургалтын орчин, технологийн нөхцөл	3	0	0	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1	0	4.5 Ажлын байран дээр ажил ахалж ажиллаж буй төгсөгчдийн саналыг судалгаа болон хөтөлбөрт тусгаж байх Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхэм нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байхад анхаарч ажиллах
5	Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	5	0	0	
6	Багшийн үйл ажиллагаа	3	1	0	6.2 Гадаад болон дотоодод сургалт семинарт хамрагдсан багш нарын ажлын үр дүн, ахиц дэвшлийг үнэлдэг байхаас гадна үзүүлдэг дэмжлэг, урамшууллыг тодорхой болгох “Багшийн хөгжлийн төв”-ийн зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны үр дүнг тооцон, өгөөжийг үнэлдэг байх
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	3	0	0	
Нийт 26 дэд шалгуур		23	3	0	
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Инженер технологийн сургуулийн “Хүнсний инженерчлэл” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Хөдөө аж ахуйн их сургууль, Инженер технологийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Хүнсний инженерчлэл
Хөтөлбөрийн индекс	D072101
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Жил бүр оролцогч болон сонирхогч талуудын уулзалтыг уламжлал болгож техник технологийн хувьд хурдацтай хөгжиж буй энэхүү салбарынхаа эрэлт хэрэгцээг судалж байх, • Хичээл бүрийнхээ CLO-г тодорхойлж өгөх • Ерөнхий суурь хичээл нь 30%-аас ихгүй, Мэргэшүүлэх хичээлүүд нь 45%-аас багагүй байлгахад анхаарч ажиллах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Период бүрийн Суралцагчдын бие даалтын ачааллыг харьцуулан судлах • Одоогийн цаг үеийн байдлаас үүдсэн онлайн сургалтдаа лаборатори хичээлүүдийг хэрхэн үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарч ажиллах • Төгсөгчдийн ажлын байртай холбоотой мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах болон эргэх холбоог сайжруулах • Хичээл заагч багш ямар ч хөндлөнгийн үнэлгээгүйгээр суралцагчдыг 100% үнэлж байгааг өөрчлөх боломжийг судлах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> • Дадлага хичээлийг хөтөлбөрт нийцсэн чиглэлээр явуулахын тулд үйлдвэр аж ахуй нэгжтэй маш сайн хамтран ажиллаж, гэрээ хийж, эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх, цаашид ажлын байраар хангах тал дээр тодорхой шат дараалалтай ажиллахад анхаарах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Богино, дунд, урт хугацааны төлөвлөлтийг богино хугацаанд дүгнэж хэлэлцдэг байх • Сургалтын хөтөлбөрт олон улсын ISO стандартуудыг оруулах чиглэлээр ажиллах
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрөөр суралцагч амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг харилцан уялдаа холбоо бүхий бүтэц, бүрэлдэхүүнтэй, сургалт, судалгааны орчин, нөхцөлөөр хангагдсан ч гадны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахгүй байгаад дүгнэлт хийх

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарыг чадавхжуулах талаар судалгаатай ажиллаж, эрдмийн зэрэг, цолыг ахиулахад чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> Сургуулийн үйл ажиллагаанд оролцогч талуудын ажлын чанарт анхаарах Нэгжүүд өөр хоорондоо харилцан уялдаатай ажиллахад анхаарах Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерийн өсөлт, ажлын байраар хангагдах хүртэлх хугацааны судалгаануудын дүгнэлт болон түүний мөрөөр хийсэн ажлуудыг тодорхой болгох Дотоод хяналт үнэлгээний ажлаа сэтгэл ханамжийн судалгаагаар хязгаарлахгүй, системтэй олон хэлбэрийн үйл ажиллагаа явуулж түүнийгээ боловсронгуй болгох
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	

Шинжээчийн багийн ахлагч: /Д.Энхцэцэг/

Шинжээчийн багийн гишүүн: /Я.Баярхүү/

Шинжээчийн багийн гишүүн: /С.Зулцэцэг/

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. ХИГМ-ийн тэнхимийн багш нар

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Ажилла сан жил	Утасны дугаар
---	----------	--------------	---------------	----------------	---------------

1	Батсамбуу Лхагвадорж	Тэнхимийн эрхлэгч	Хичээл ордоггүй	27	91929899
2	Бөкей Эркигүл	Ахлах багш	1.Хүнсний биоисгэлтийн технологи 2.Исгэлтийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	2	99180956
3	Ууш Оюунцэцэг	Багш	1.Мэргэжлийн удиртгал, 2.Хүнс үйлдвэрлэлийн процесс аппарат 3.Мах боловсруулах оног төхөөрөмж 4.Сүү боловсруулах тоног төхөөрөмж	17	99177075
4	Рагчаа Алтанзул	Багш	1.Шингэний механик 2.Шэрилын үйлдвэрийн тоног төхөөрөмж 3.Талх, чихэрийн үйлдвэрийн тоног төхөөрөмж	15	99158156
5	Баасанжаргал Буянчимэг	Багш	1.Хүнсний түүхий эдийн үндэс, физик химийн боловсруулалт 2.Нээшлөх технологи тоног төхөөрөмж, сав баглаа боодол 3.Зохистой хооллолт ба физиологийн үндэс	2	90110553
6	Төмөрбаатар Энхбат	Багш	1.Гурилын үйлдвэрийн технологи 2.Хүнсний үйлдвэрийн урсгал шугам	5	90082210
7	Барцэрэн Нямгэрэл	Ахлах багш	1.Хүнсний үйлдвэрийн менежмент, чанарын удирдлага		99086597
8	Бадрах Долгормаа	Багш	1.Хий шингэний механик	15	88007746

II. Хүнсний инженерчлэл хөтөлбөрөөр суралцаж буй оюутны төлөөлөл

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	Н.Болормаа	4	Хөвсгөл, дотуур байр	88480007
2	Б.Буян-Арвижих	4	Увс аймаг	86466646
3	О.Золбоо	4	Улаанбаатар хот,	86011610
4	Б.Дашдулам	4	Өвөрхангай аймаг	95260316
5	Э.Аюурзана	4	Баянхонгор аймаг, дотуур байр,	86341130
6	Б.Туяа	4	Улаанбаатар хот	86510609
7	О.Сугир	4	Дундговь аймаг	99346412

8	Б.Лхагвадорж	4	Баянхонгор аймаг	88299928
9	А.Удвалцэцэг	3	Улаанбаатар хот	88303678
10	Д.Учрал	3	Хэнтий аймаг	80430903
11	Т.Төгсжаргал	3	Дорноговь аймаг, дотуур байр	99733632
12	М.Идэр	3	Улаанбаатар хот	95259533
13	Д.Номин	3	Архангай аймаг	95169163
14	О.Болор-Оюун	3	Улаанбаатар хот	99307190
15	Б.Нарантуяа	2	Хэнтий аймаг	99168125
16	Г.Уранцэцэг	2	Сэлэнгэ	89134723
17	Н.Балжинням	2	Увс	91310320
18	Б.Батцэцэг	1	Ховд аймаг /хос хөтөлбөр/	99437037
19	Ч.Чимэддолгор	1	Өвөрхангай /хос хөтөлбөр/	89201512
20	Э.Анужин	1	Улаанбаатар хот	95731901

III. Хүнсний инженерчлэл хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдийн төлөөлөл

№	Овог нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Ц.Цацрал	2016	KFC салбарын менежер	Таван богд	99944812
2	Г.Цэцэнбилэг	2017	MCS	Сосо-Cola ХХК	88864793
3	Ц.Солонго	2018	Мастер технологич	"Талх чихэр" ХК	88139285
4	Т.Лхагвамаа	2018	Эрүүл ахуйч	"Жем" ХХК	89859779
5	Г.Тэргэл	2019	Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн	ХУД	88574666
6	С.Номин-Эрдэнэ	2019	Технологич /Ээлжийн мастер/	"Талх чихэр" ХК	99622044
7	Д.Жамба	2020	Оперторчин	"АПУ" ХХК	88199262
8	Г.Номин-Эрдэнэ	2020	"Талх чихэр", Мастер технологич	"Талх чихэр" ХК	80320794
9	Б.Булганбаяр	2016	Оперторчин	"Жүр үр" ХХК	86804049
10	Б.Түвшинзаяа	2015	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн инженер	"Атар өргөө" ХХК	89005083
11	Б.Сайнзаяа	2018	Технологич мастер	"Атар өргөө",	88950219
12	М.Бямбажаргал	2018	Мастер технологич	"Сүү" ХХК	89035887
13	Ц.Баяртуяа	2016	Мастер	"Витавит"	99043415

IV. Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Ч.Нарангэрэл	"Витафит-милк" ХХК	Сүүний үйлдвэр хариуцсан захирал	91925669
2	С.Оюунбилэг	"Сүү" ХК	Технологийн албаны дарга	88027687
3	Г.Баярмаа	"Өгөөж" ХХК	Ерөнхий технологич	94777718
4	Д.Мөнхбаяр	"Хатансүйх" импэкс ХХК	Гүйцэтгэх захирал	99056621
5	Ц.Доржсүрэн	Технологийн дээд сургууль	Сургалт, хүмүүжил хариуцсан захирал	99838089
6	Ч.Оюунцэцэг	МХЕГ	Хүнсний чанар стандарт хариуцсан ахлах байцаагч	99054208
7	Т.Хишигтуяа	ХХААХҮЯ	Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар ахлах мэргэжилтэн	99136678
8	Ц.Сайнбаяр	АПУ дэйри ХХК	Сүүний үйлдвэр үйлдвэрлэлийн менежер	99029494
9	Э.Ган-эрдэнэ	"Баясах фүүдс" ХХК	"Багро" хүнсний үйлдвэрийн захирал	88177494
10	П.Анхбаяр	"Жүр үр" ХХК	Төв үйлдвэрийн дарга	80083998
11	С.Тамираа	"Талх чихэр" ХК	Ерөнхий менежер	99198973
12	Д.Уранзаяа	"Монжүүс" ХХК	Чанарын албаны дарга	88908083
13	Ж.Сосоржав	"Хүн-од" ХХК	Ерөнхий технологич	96654415
14	В.Отгонтуяа	"Траст трейд" ХХК	Ерөнхий технологич	94017502
15	Т.Цэрэнпагам	"TESO" корпораци	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн албаны дарга	94110130

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 232
Факс: 34 17 70, И-мэйл: engineer@mul.s.edu.mn
Вэб сайт: www.mul.s.edu.mn

БМИУЗ-ийн ажлын албанд

2021.04.26 № 01/33
танай _____ -ны № _____ -т

Албан хариу хүргүүлэх тухай

Инженер технологийн сургуулийн “Хүнсний инженерчлэл”-ийн бакалаврын хөтөлбөрийн Магадлан итгэмжлэлийн урьдчилсан тайланг шалгуур, шаардлагын дагуу бэлтгэн хүргүүлсэн бөгөөд энэхүү ажлын хүрээнд шинжээчдийн баг 2021 оны 3-р сарын 09-10-ны өдрүүдэд тус сургууль дээр ажиллан тайлан, зөвлөмжөө 4-р сарын 05-ны өдөр бидэнд ирүүлсэн.

Бид шинжээчдийн багийн ирүүлсэн ажлын тайлантай танилцаж тухайн тайланд тусгасан заавар, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байгаагаа энэхүү албан бичгээр илэрхийлж байна.

Цаашид тайланд тусгасан заавар, зөвлөмжийг ажлын төлөвлөгөөндөө тусган, хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАХИРАЛ



Ж.МӨНГӨН